

ᠪᠠᠶ᠋ᠠᠨ-ᠥᠯᠭᠢᠢ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ
ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ ᠠᠭᠳᠢᠲᠤᠶᠢᠨ ᠭᠠᠰᠠᠷ

**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**НӨХӨН СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, НЭР
ДЭВШИГЧИД ИРГЭД, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭЭС
ХАНДИВ АВААГҮЙ БАЙНА**

**АУДИТЫН СЭДЭВ: СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2026 ОНЫ НӨХӨН
СОНГУУЛЬД ОРОЛЦСОН НАМ, ЭВСЭЛ БОЛОН
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧИЙН ЗАРДЛЫН
ТАЙЛАНГ ХЯНАЖ, ОЛОН НИЙТЭД
МЭДЭЭЛЭХ**

АУДИТЫН КОД: БӨА-2026/50/ШТА-НА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудиторовын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч,
аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Назгүл

Утас: 99427301 Цахим хаяг: nazguld@audit.gov.mn

Аудитор: Р.Баярмаа

Утас: 99265539 Цахим хаяг: Bayarmaar@audit.gov.mn

Аудитор: Х.Еркебулан

Утас: 99999844 Цахим хаяг: erkebulankh@audit.gov.mn

Өлгий. 2026 он

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар.....	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	3
Ерөнхий мэдээлэл	4
1. Нэр дэвшигчид сонгуулийн зардлын тайландаа аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулж, хуулийн хугацаанд ирүүлсэн байна	4
1.1 Нөхөн сонгуульд оролцсон намын хороод сонгуулийн зардлын данс нээж ажиллуулаагүй байна	4
1.2 Нэр дэвшигчид сонгуулийн зардлын тайланд дүгнэлт гаргууж ирүүлсэн байна	5
2. Нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид иргэд, хуулийн этгээдээс хандив аваагүй байна	5
2.1 Нэр дэвшигчид сонгуулийн зардлын дансандаа эх үүсвэр бүрдүүлээгүй байна	5
2.2 Сонгуульд оролцсон нам болон нэр дэвшигчид хандив аваагүй байна.....	5
3. Дүгнэлт	6
ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:	7

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд АНСДИТХСТ хуулийн 57 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторов 2025 оны “Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” А/32 дугаар тушаал, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийв.
Аудитын зорилт	Баян-Өлгий аймгийн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн хувийн аудитын компаниар дүгнэлт гаргуулж ирүүлсэн сонгуулийн зардлын тайланг хянаж, нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэв.
Аудитын хамарсан хүрээ	Аудитад сумын ИТХ-ын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчдийн хувийн аудитын компаниар дүгнэлт гаргаж ирүүлсэн сонгуулийн зардлын тайлан, холбогдох нотлох баримтуудыг хамруулав.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4000 дугаар стандартууд, Монгол Улсын Төрийн аудитын стандарт-Нийцлийн аудит MNS 6817-6:2020, МУЕА-ын тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар аргачлал”, “Нийцлийн аудитын заавар аргачлал”-ыг баримтлан сонгуулийн зардлын тайлангийн талаар нам эвсэл, нэр дэвшигч, хувийн аудитын компаний холбогдох албан тушаалтнуудаас асуулга, лавлагаа авах, хувийн аудитын компаний гаргасан дүгнэлтийн мэдээллийг нэгтгэх, хандив өгсөн иргэн, аж ахуйн нэгжийн талаарх судалгаа, мэдээллийг нэгтгэх, баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулав.
Аудитын бүрэлдэхүүн, удирдлага зохион байгуулалт	Аудитыг дарга, тэргүүлэх аудиторовын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Женисбек хянан удирдаж, үе шатны хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Назгүл, аудитор Р.Баярмаа, Х.Еркебулан нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх

Ерөнхий мэдээлэл

Сонгуулийн ерөнхий хорооноос Баян-Өлгий аймгийн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуулийг Алтанцөгц сумын 1, Ногооннуур сумын 2 мандатад зохион байгуулахаар тогтоосон байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 121 дүгээр тогтоолоор сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийг зохион байгуулах аймгийн Сонгуулийн хороог 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

Ногооннуур сумын сонгуулийн хороо байгуулагдаагүй тул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгууль явагдаагүй байна.

Алтанцөгц сумын Сонгуулийн хороог Алтанцөгц сумын ИТХ-ын 2026 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 47 тоот тогтоолоор байгуулсан байна.

Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сумын 3 дугаар багийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль 2026 оны 6 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулагдаж, Монгол Ардын намаас 1, Ардчилсан намаас 1 хүн тус тус нэр дэвшсэн байна.

1. Нэр дэвшигчид сонгуулийн зардлын тайландаа аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулж, хуулийн хугацаанд ирүүлсэн байна

1.1 Нөхөн сонгуульд оролцсон намын хороод сонгуулийн зардлын данс нээж ажиллуулаагүй байна

Алтанцөгц сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралд нэр дэвшсэн 2 нэр дэвшигч “Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуул”-ийн 50 дугаар зүйлийн 50.2¹-т заасны дагуу сонгуулийн зардлын дансыг нээлгэсэн байна.

Алтанцөгц сумын ИТХ-ын 2026 нөхөн сонгуультай холбоотой ямар нэгэн ханвивын данс нээж ажиллуулаагүй талаар аймгийн Монгол Ардын намын хороо 2026 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 14 тоот, аймгийн Ардчилсан намын хороо 2026 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 01/221 тоот албан бичгээр тайлбар ирүүлсэн ба энэ нь АНСДИТХСТ хуулийн 50 дугаар зүйлийн 50.2², 50.3 дахь заалттай нийцээгүй байна.

Нэр дэвшсэн иргэд АНСДИТХСТ хуулийн 50 дугаар зүйлийн 50.3-т заасан хугацаанд сонгуулийн зардлын дансаа Төрийн аудитын байгууллагад мэдэгдэж бүртгүүлсэн байна.

50.2. Нам, эвсэл болон нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаар бүртгэх тухай шийдвэр гарснаас хойш энэ хууль болон банкны хууль тогтоомжид нийцүүлэн сонгуулийн зардлын дансыг нээлгэнэ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх

1.2 Нэр дэвшигчид сонгуулийн зардлын тайланд дүгнэлт гаргууж ирүүлсэн байна

Алтанцөгц сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон аймгийн Монгол Ардын нам, Ардчилсан намын хороо нь сонгуулийн зардлын тайлан гаргаагүй, аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулаагүй байна.

Алтанцөгц сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2026 оны нөхөн сонгуульд аймгийн Монгол Ардын нам, Ардчилсан намаас нэр дэвшиж оролцсон 2 нэр дэвшигч сонгуулийн зардлын тайландаа “Өлгий аудит” ХХК-аар аудитын дүгнэлт гаргуулж, хуулийн хугацаанд аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

“Өлгий аудит” ХХК нь нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайланд зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна.

2. Нөхөн сонгуульд оролцсон нам, нэр дэвшигчид иргэд, хуулийн этгээдээс хандив аваагүй байна

2.1 Нэр дэвшигчид сонгуулийн зардлын дансандаа эх үүсвэр бүрдүүлээгүй байна

Нэр дэвшигчдийн ирүүлсэн сонгуулийн зардлын тайланг хянаж үзэхэд Монгол ардын намаас нэр дэвшигчийн дансанд 1.0 мянган төгрөгийн орлого орсон бол Ардчилсан намаас нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дансанд ямар нэг орлого ороогүй, нэр дэвшигчид сонгуулийн зардалд санхүүгийн эх үүсвэр бүрдүүлээгүй байна.

Монгол ардын намаас нэр дэвшигч сонгуулийн зардлын тайландаа 1.0 мянган төгрөгийн орлого, зарлага тайлагнаж ирүүлсэн ба Ардчилсан намаас нэр дэвшигч иргэн сонгуулийн зардлын дансандаа 0 төгрөгийн буюу “Х” тайлан ирүүлсэн байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчидийн хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5-д заасны дагуу аймгийн ХААН банкны салбараас тухайн банкинд хүсэлт гарган сонгуулийн зардлын данс нээлгэсэн нэр дэвшигч 2 иргэний дансны хуулгыг 2026 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 5180/599 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна

2.2 Сонгуульд оролцсон нам болон нэр дэвшигчид хандив аваагүй байна

Аймгийн Монгол Ардын нам, Ардчилсан намаас нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын тайлангаар мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр ямар нэг хандив аваагүй байна.

Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчидийн хурлын сонгуулийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1.³-т заасны дагуу нам, эвсэл, нэр дэвшигчид иргэд, хуулийн этгээдүүдээс хандив аваагүй байгаа ба нийтэд мэдээлэх нэг сая

57.1. “Төрийн аудитын орон нутаг дахь салбар байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх бөгөөд нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд мэдээлнэ”

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх

ба түүнээс дээш хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш хандив өгсөн хуулийн этгээд байхгүй байна.

3. Дүгнэлт

1. Сумын ИТХ-ын 2026 нөхөн сонгуульд нэр дэвшигчид АНСДИТХСТ хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын дансаа Төрийн аудитын байгууллагад мэдэгдэж бүртгүүлсэн байна.

2. Нэр дэвшигчид сонгуулийн зардлын тайландаа аудитын хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулж, хуульд заасан хугацаанд ирүүлсэн.

2. Нөхөн сонгуульд оролцсон намын хороод сонгуулийн зардлын данс нээж ажиллуулаагүй байна.

4. Нэр дэвшигчид иргэд, хуулийн этгээдүүдээс мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр хандив аваагүй байна.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ:



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2026 оны 02 сарын 08 өдөр

Дугаар

1/22

Өлгий

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18 дугаар хэсгийн 18.9, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2025 оны "Эрх шилжүүлэх тухай" А/175 дугаар тушаалын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны нөхөн сонгуульд оролцсон нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн зардлын тайланг хянаж, олон нийтэд мэдээлэх" нийцлийн аудитын тайланг хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг www.audit.mn цахим хуудсаар нийтэд мэдээлсүгэй.

2. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 7 хоногт багтаан аудитын тайлан болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэж өгөхийг аудитын багт даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагыг мэдээллээр хангаж ажиллахыг ахлах аудитор (Д.Назгүл)-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Х.ЖЕНИСБЕК



82260100019